

Хурлын тэмдэглэл

“Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр “Айтүүлс” ХК-ийн фэйсбүүк пэйж хуудсаар live хэлбэрээр шууд дамжуулагдсан. Цахим хурал 15:00-17:45 цагийн хооронд болов.

Хуралд оролцсон:

Хурлын дарга: Г.Хатанболд

Гүйцэтгэх захирал: Б. Тамир

Хурлын тооллогын комисс: О.Далайхүү, А.Мөнхбилэг, Д.Жигжид

Хурал зохион байгуулах комисс: Г.Янжинлхам, Д.Билэгжаргал, Б.Мөнхцэлмүүн

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүн танилцуулах
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах
3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах
4. Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг танилцуулах
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төсөв батлуулах
7. Компанийн дүрэмт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

ХУРЛЫН ИРЦ:

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 17,585,776 ширхэг хувьцаа эзэмшиж буй 10 хувьцаа эзэмшигч буюу 51.04 хувь болж хурал хүчин төгөлдөрт тооцогдов.

Айтүүлс ХК-ийн Тооллогын комиссын гишүүн Д.Жигжид хурлын ирцийг танилцуулж хурлыг хүчин төгөлдөр эхэлж байгааг мэдэгдсэнээр хурал эхлэв.

Хурлын дарга Г.Хатанболд хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулсны дараа, хурлын дэгийн дагуу Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааг товч танилцуулж, хурлын дэгийн дагуу Хувьцаа эзэмшигч нарт дараах танилцуулгуудыг хүргэв.

1. Гүйцэтгэх захирал Б. Тамир компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, биелэлт, санхүүгийн тайлан, 2022 оны стратеги төлөвлөгөөний талаар танилцуулав.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г.Хатанболд Айтүүлс ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлт болон 2021 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.
3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Янжинлхам ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг хийж, ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төсвийг Хувьцаа эзэмшигч нарт танилцуулав. Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нийт 10 хүн нэр дэвшсэн бөгөөд үүнээс хамгийн их санал авсан 9 гишүүн буюу Ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнийг сонгоно.
8. ХЭХурлын дарга Г. Хатанболд Компанийн дүрэмт нэмэлт өөрчлөлт оруулах тухай танилцуулж мэдээлэл өгсөн.

Санал хураалт:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 17,564,827 ширхэг хувьцааны санал буюу 99.8 хувь нь зөвшөөрсөн санал, 19,899 ширхэг хувьцааны санал буюу 0.1 хувь нь түдгэлзсэн санал өгснийг тогтоосугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төсвийг батлах тухай санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 17,564,827 ширхэг хувьцааны санал буюу 99.8 хувь нь зөвшөөрсөн санал, 19,899 ширхэг хувьцааны санал буюу 0.1 хувь нь түдгэлзсэн санал өгснийг тогтоосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай – Тус асуудалд Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл 77.4 дэх хэсэгт заасны дагуу санал хураалтыг кумулятив аргаар явуулсан бөгөөд ТУЗ-ийн ердийн гишүүнд 6 хүн, ТУЗ-ийн хараат бус гишүүнд 4 хүн нэр дэвшсэнээс хамгийн их санал авсан ТУЗ-ийн 9 гишүүн сонгогдлоо.
4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 1,996 ширхэг хувьцааны санал буюу 0.01 хувь нь зөвшөөрсөн санал, 17,563,920 ширхэг хувьцааны санал буюу 99.8 хувь нь татгалзсан санал, 18,810 ширхэг хувьцааны санал буюу 0.1 хувь нь түдгэлзсэн санал тус тус өгснийг тогтоосугай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.
2. ТУЗ-ийн гишүүдээр дараах нэр бүхий 9 гишүүдийг сонгов.

Ердийн гишүүнд: Г. Хатанболд, А. Баттамир, Н. Улаанхүү, Б. Тамир, Д. Даваа, Б. Амгаланбаатар

Хараат бус гишүүнд: Г. Гантуяа, Н. Жавхлан, З. Саранчимэг

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төсвийг 47,107,360 төгрөгөөр батлав.

Хурлын дарга Г.Хатанболд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэн хурлыг хааж үг хэлснээр 17:45 цагт хурал өндөрлөв.

Хурлын тэмдэглэлд хурал дээр танилцуулсан танилцуулга /PPT/-ыг хавсаргав.

Тэмдэглэлтэй танилцсан:


Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга:



Г.ХАТАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:



Г.ЯНЖИНЛХАМ